



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/179

Улаанбаатар хот

### Харьяа хүрээлэнгийн захирлыг сонгон шалгаруулах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дүрмийн 4.14.14, 10.2 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагааны журмын 5.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус их сургуулийн харьяа Уул уурхайн хүрээлэн, Ой модны сургалт, судалгааны хүрээлэнгийн захирлыг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Д.Цолмонбаатар	Эрдэм шинжилгээ, технологийн газрын захирал
Гишүүд:	Ж.Арслан	Судалгаа хөгжүүлэлтийн албаны дарга
	Б.Одгэрэл	Судалгаа хөгжүүлэлтийн албаны ахлах мэргэжилтэн
	Л.Мөнхтуяа	Боловсрол, шинжлэх ухааны ямны ШУТБИХХЗГ-ын Салбарын хүний нөөц, хамтарсан төсөл, хөтөлбөр, түгээн дэлгэрүүлэлтийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)
Нарийн бичгийн дарга:	Д.Мягмарсүрэн	Хүний нөөцийн албаны дарга

2. ШУТИС-ийн харьяа хүрээлэнгийн захирлыг сонгон шалгаруулах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Сонгон шалгаруулалтыг 2023 оны 06 дугаар сард багтаан удирдамжийн дагуу зохион байгуулж, танилцуулахыг ажлын хэсэг (Д.Цолмонбаатар)-т үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Т.НАМНАН

367040864

ШУТИС-ийн захирлын 2023 оны 05  
дугаар сарын 19-ны өдрийн 4/179  
дугаар тушаалын хавсралт



## ШУТИС-ИЙН ХАРЬЯА ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРЛЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ УДИРДАМЖ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 ШУТИС-ийн харьяа Уул уурхайн хүрээлэн, Ой модны сургалт, судалгааны хүрээлэнгийн захирлыг сонгон шалгаруулахтай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү удирдамжийг баримтална.
- 1.2 Хүрээлэнгийн захирлын албан тушаалд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах ажлыг ШУТИС-ийн Захирлын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг зохион байгуулна.
- 1.3 Тус ажлын хэсэг нь хүний эрх, хувийн болон мэргэжлийн нэр хүндийг хүндэтгэх, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал үүслээр нь ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш хандах, хууль тогтоомж, шударга ёсыг дээдлэх, нууцыг хадгалах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчимд тулгуурлан шалгаруулалтыг зохион байгуулна.
- 1.4 Тус ажлын хэсэг нь шалгаруулалттай холбоотой аливаа асуудал, санал, гомдал, маргааныг хурлаараа хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 1.5 Сонгон шалгаруулах ажилтай холбогдон гарах зардлыг ШУТИС-ийн төвлөрсөн арга хэмжээний зардлаас гаргана.

### Хоёр. Захирлын албан тушаалд нэр дэвшигчид тавих шаардлага

2.1. Харьяа хүрээлэнгийн захирлын албан тушаалд нэр дэвшигч нь тус албан тушаалын тодорхойлолтод заасан шалгуур, шаардлагыг хангасан байх. Үүнд:

Боловсрол	Доктор (Ph.D) болон түүнээс зэрэгтэй
Мэргэжил	Хүрээлэнгийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, судалгааны чиглэлд хамаарах
Мэргэшил	- Тухайн хүрээлэнгийн судалгааны чиглэлээр мэргэшсэн байх - Тухайн салбарт хамаарах мэргэжлийн чиглэлээр доктор (Ph.D) зэрэг хамгаалсан байх
Туршлага	Шинжлэх ухаан, дээд боловсролын байгууллагад 10-аас доошгүй жил, үүнээс хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, салбар, тэнхим, лабораторийн эрхлэгч, түүнтэй дүйцэх шинжлэх ухаан, дээд боловсролын байгууллагын удирдах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх

2.2. Тухайн хүрээлэнгийн судалгааны чиглэлээр сүүлийн 5 жилд гадаад,

ШУТИС-ийн захирлын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 4179 дугаар тушаалын хавсралт



дотоодын мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн байх

- 2.3. Гадаадын их сургуульд зочин профессороор ажилласан, гадаадын их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад ажилласан бол давуу тал болно.

### Гурав. Сонгон шалгаруулалтад бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг

3.1 Нэр дэвшигч дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

- Төрийн албан хаагчийн анкет, зурагтай (Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолоор баталсан анкет)
- Иргэний үнэмлэхний хуулбар (E-mongolia системээс лавлагаа авч болно)
- Боловсролын түвшин, эрдмийн зэрэг, цолыг тодорхойлсон баримт бичиг (хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах)
- Тухайн хүрээлэнгийн захирлын албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажлын туршлагыг хангасан тухай нотлох баримт (нийгмийн даатгалын дэвтэр, хөдөлмөрийн дэвтэр, албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал шийдвэр)-ийн хуулбар, лавлагаа
- Бүтээлийн жагсаалт
- Тухайн хүрээлэнг хөгжүүлэх хөтөлбөр (тухайн хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, санхүү, бодлого төлөвлөлт, үйл ажиллагааг хэрхэн хөгжүүлэх, хүрэх үр дүн зэргийг агуулсан байна)
- Хөтөлбөрийг тухайн хүрээлэнгийн хамт олонд танилцуулсан хурлын тэмдэглэл
- Шаардлагатай бол мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийн хуулбар
- “4 х 6”-ийн хэмжээтэй цээж зураг 2 хувь

*Тайлбар: Бүрдүүлсэн баримт бичгийг нотариатаар баталгаажуулсан байхыг шаардахгүй бөгөөд баримт бичгийн үнэн зөвийг хүсэлт гаргасан иргэн өөрөө бүрэн хариуцна.*

### Дөрөв. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах ба бүртгэх

- 4.1. Дээр дурдсан шалгуур, шаардлагыг хангасан, сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн иргэн материалыг цаасан хэлбэрээр, А4 хэмжээний дугтуйнд хийж битүүмжлэн зарласан хугацаанд ШУТИС-ийн хичээлийн төв байрны 211 тоот (Хүний нөөцийн алба) өрөөнд өөрийн биеэр хүлээлгэн өгнө.

ШУТИС-ийн захирлын 2023 оны 05  
дугаар сарын 09-ны өдрийн А/179  
дугаар тушаалын хавсралт



- 4.2. Хүний нөөцийн алба сонгон шалгаруулалтын материал хүлээн авах хугацаа дуусмагц нэр дэвшигчдийн бүртгэл үйлдэж, битүүмжилсэн дугтуйг задлахгүйгээр ажлын хэсэгт хүлээлгэн өгнө.

**Тав. Захирлын албан тушаалд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах ажиллагаа**

- 5.1. Ажлын хэсэг тогтоосон өдөр, цагт багтаан нэр дэвшигчдийн холбогдох материалтай танилцана.
- 5.2. Ажлын хэсэг хүрээлэнгийн захирлын албан тушаалд нэр дэвшигчийн бүрдүүлсэн баримт бичиг нь тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан эсэхийг нэг бүрчлэн шалгаж, баримтыг дутуу бүрдүүлсэн болон шаардлага хангаагүй тохиолдолд тухайн нэр дэвшигчийг сонгон шалгаруулалтаас хасах үндэслэл болно.
- 5.3. Ажлын хэсэг шаардлагатай гэж үзвэл баримт бичгийн үнэн зөвийг магадлах зорилгоор нэмэлт материал шаардах, нягтлах эрхтэй.
- 5.4. Нэр дэвшигч хүрээлэнг хөгжүүлэх хөтөлбөрөө ажлын хэсэгт танилцуулна. Ажлын хэсэг нэр дэвшигч бүртэй ярилцлага хийж оноогоор үнэлнэ.
- 5.5. Нэр дэвшигч бүрдүүлсэн материалын эх хувийг ярилцлагад орохдоо авчирна.
- 5.6. Ажлын хэсэг хамгийн өндөр оноо авсан 2 нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, ШУТИС-ийн Захиралд холбогдох материалыг хүргүүлнэ.
- 5.7. Ажлын хэсгээс ирүүлсэн 2 нэр дэвшигчээс ШУТИС-ийн захирал эцэслэн сонгож, ШУТИС-ийн харьяа хүрээлэнгийн захирлын албан тушаалд томилно.
- 5.8. Сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг захирлын албан тушаалд томилохгүй.